



# ЦЭНХЭР АЛТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ.

2021.III CAP

## Ш.МЯГМАР: БИДНИЙ АЖИЛ БҮХЭНД ХАМААТАЙ



*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-ын дарга Ш.Мягмартай уулзаж ярилцлаа.*

*-Усны газар байгуулагдаж ажил үйлсээ эхлээд хагас жил орчмын хугацаа өнгөрч байна. Хичнээн хэлтэс тасаг, хүч бүрэлдхүүнтэй ажиллаж байна вэ?*

-2020 оны нэгдүгээр сард УИХ-аас Усны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Усны агентлаг бий болох нөхцөл бүрдсэн юм. Улмаар 2020 оны дөрөвдүгээр сард Засгийн газрын тогтоол гарч, агентлагийн бүтэц бүрэлдэхүүн батлагдлаа. Ингээд бэлтгэл ажил хийгдэж, бид намар найман сарын дундуур тулгаа тулж, өрхөө татсан. Манайх одоо “Удирдлага санхүүгийн хэлтэс”, “Усны нөөцийн хэлтэс”, “Ус ашиглалтын хэлтэс”, “Усны хяналт шинжилгээний хэлтэс” гэсэн дөрвөн хэлтэстэй 38 хүний бүрэлдхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

*-Танай агентлагийн үйл ажиллагааны стратеги, тэргүүлэх чиглэлийг юу юу гэж зааж тодорхойлсон байдаг юм бэ?*

-Засгийн газрын үйл ажиллагааны бодлого болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх ажлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлэхдээ нэгдмэл арга зүйгээр усны нөөц, түүний сав

газрыг хамгаалах, усны нөөцийг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, нөхөн сэргээх, хур тундасны усыг хуримтлуулах, усны нөөцийг арвижуулах, хүн амын ундны ус хангамж, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй хангахад чиглэгдэж байна.

*-Агентлаг нь устай холбоотой бүхий л байгууллагуудыг нэгдсэн арга зүйгээр хангах уу?*

-Тийм ээ. Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана. Мөн 21 Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн байгаль орчин алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

*-Шинээр “айл өрх” болоод танайх хамгийн түрүүнд ямар ажил үйлсийг эхлүүлжэ байв даа?*

-Айл болж байгаа шинэ газар чинь боловсон хүчнээ бүрдүүлэх, байр саваа олох, ширээ сандал,





Усны газрын хамт олон. 2021.03.18.

техник тоног төхөөрөмжөө суурилуулахаас эхлээд ямар их ажил болдог билээ дээ. Ингэж бужигнасаар байгаад есөн сард л үйл ажиллагаа маань жигдэрч эхэлсэн дээ. Бид хамгийн түрүүнд “Цэнхэр Алт усаа хайрлая” аяныг улс орон даяар эхлүүлсэн. Энэ аяны хүрээнд олон талт ажлыг зохион байгуулсаан. Усаа хайрлах, гамнах, зохистой хэрэглэх тухай олон тооны видео контентыг хийж цахимаар түгээсэн. Эдгээр бүтээлийг 11 сая гаруй хүн үзэж, биднийг дэмжиж хандалт хийж, санал сэтгэгдлээ хуваалцсан байдаг. Өөрсдийн үйл ажиллагаа болон усны үнэ цэнийг таниулах, ойлгуулах, сурталчлах ажил бас гол зүйлийн нэг шүү.

**-Шинэ тутам байгуулагдсан агентлаг үй зайгүй их ажилтай байгаа нь мэдээж. Яг одоо танай хамт олон ямар ямар ажил дээр төвлөрч байна вэ?**

-Олон ажил зэрэг зэрэг хийгдэж байна даа. Олон зориулалтай усан цогцолбор барих, 10 аймагт 10 усан сан, УЦС барих ажлыг эхлүүлэх суурь судалгаа, ТЭЗҮ боловсруулах болон говийн бүс дэх үйлдвэр уурхайн усан хангамжийг хэрхэн

шийдвэрлэх зэрэг ажлууд дээр ид ажиллаж байна. Манай орны хөх сувд болсон Хөвсгөл далайд живсэн машин техникүүдийг татан гаргах ажлын даалгавар боловсруулах, урьдчилсан төсөв, төлөвлөгөөг гаргах ажлууд хийгдэж байна

**-“Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”, “Ус” Үндэсний хөтөлбөр зэрэг томоохон хөтөлбөрүүд хэрэгжээд дуусч байгаа. Тэдгээрийн үр дүнг нэгтгэх, дүгнэх ажил бас танай дээр төвлөрч хийгдэж байна уу?**

-Тийм ээ. Ус Үндэсний хөтөлбөрийн хөтөлбөр, улсын Усны нөөцийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг, дүгнэж, Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого хөтөлбөртэй усны бодлого хөтөлбөрийг нийцүүлэх шаардлага бидний өмнө тавигдаж байна. Түүнээс гадна Сав газрын захиргааны гүйцэтгэлийн тайлан төлөвлөгөөг хянах, дүгнэх, заавар зөвлөмж өгөх ажил хийгдэж байна. Ер нь нэлээн өндөр ачаалалтай ажиллаж байна шүү.

**-Томоохон рашаануудын нөөцийг дахин тогтоох ажлыг бас эхлүүлээд байгаа гэв үү?**

-Хужирт, Шаргалжуут, Могод, Цэнхэр гэхчилэн улсын чанартай томоохон рашааны нөөцийг судалж, тогтоох, дахин үнэлэх ажлуудыг хийж байна. Жар, далаад онд нөөцийг нь тогтоосноос хойш дахин эргэж судлаагүй орхигдсон байсан. Тэдгээрийг дахин судалж, үнэлгээ хийж байна. Энэ бас онцгой чухал ажил болж байгаа. Ялангуяа эдгээр судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, тайлан мэдээ нь манай Сав газрын захиргааны өдөр тутмын үйл ажиллагаанд ихээхэн үр өгөөжөө өгнө гэж бодож байна.

**-Улаанбаатар хотын дагуул хот болох “Майдар” хотын төсөл хүмүүсийн хүсэл сонирхлыг татсаар байгаа. Тийм хот суурингуудын усан хангамжийг мэдээж хамгийн түрүүнд судалж тооцдог болов уу?**

-Хамгийн түрүүнд судалж, тооцох зүйл бол мэдээж ус шүү дээ. Усгүй бол хичнээн ч сайхан барилга байшин, хот суурин босгоод ямар амьдрал байх билээ. Бид нийслэл Улаанбаатарын дагуул хот болох “Майдар” хотын усан хангамжийн асуудлыг шийдэж байгаа. Майдар хотын усны эх үүсвэрийн хайгуулын

ажлын сонгон шалгаруулалт хийгдэж, “Дунар-Од” ХХК-тай гэрээ байгуулсан. Улмаар усны хайгуулын ажил, судалгааны ажлын тайланг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн нөөцийг баталсан.

**-Томоохон урсацтай голоос ус багатай говь талын нутаг руу ус татах тухай яригдаад л байдаг. Энэ ажлын хувь заяа юу болсон бэ? Тэр хэрэгжиж болох төсөл санаа юу? Эсвэл зүгээр л хий хоосон мөрөөдөл байв уу?**

-Тэдгээр төслийн судалгааны ажлууд явагдаад л байгаа шүү дээ. Усан цахилгаан станцын ажлууд явагдаж байна. Тийм том ажил, төсөл хөтөлбөрүүд нэг хоёрхон жил яригдаад хэрэгжих гэж байхгүй. Урт удаан зам мөрийг туулж байж ажил болдог. Монгол орны гадаргын усны хуримтлал бий болгох, урсацын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх боломжтой 33 байршилыг сонгосон юм. Үүнээс нарийвчилсан судалгаа хийж, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх боломжтой, эдийн засаг болон экологийн хувьд ач холбогдолтой, 10 байршлыг сонгож зохих ажлуудыг эхлээд байгаа.

**-Говийн бүсийн ус хангамжийн нэмэгдүүлэх ямар ямар төсөл яригдаж байгаа билээ?**

-Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2020-204 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэлд “Орхон говь”, “Хэрлэн

говь” төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр төсөл нь гадаргын усны эх үүсвэрийг ашиглах боломжийг бүрдүүлэхээс гадна нь байгаль экологит тэмцлийг хангах, улсын эдийн засгийн өсөлтөд тодорхой нөлөө үзүүлнэ. Энэхүү төслүүд нь өмнөд говийн бүсийн усны хэрэгцээг хангах томоохон төсөл юм.

**-Хэдий хэмжээний замыг туулж байж, хэрэгцээт газраа очно гэж тооцож байгаа билээ.**

-Орхон-Онги төсөл, “Хэрлэн-Тооно” гэж хоёр төслийн тухай тодруулъя. “Хэрлэн Тооно” төсөл нь Сайншандын аж үйлдвэрийн парк хүртэл 235 км урт, 800 мм-ийн диаметртэй хос зөөлөн ширмэн хоолойгоор хоёр өргөлтийн насос станцаар өргөж хүргэх юм. Нөгөөх нь болохоор Орхон голын Майхан толгойн орчим боомт барьснаар урсац тохируулгын усан сан үүсгэж Онги голын урсацыг тэтгэх усыг хүргэх боломж бүрдэнэ. Орхон голоос ус татаж Онги голын урсац болон Улааннуурын урсацыг тэтгэхээс гадна далд шугам хоолойгоор говийн бүсийн аймаг сумдын усны хэрэглээ үйлдвэр уурхайн хэрэгцээг хангах юм. Төслийн ус түгээх шугамын урт нь ойролцоогоор 535 км.

**-“Усны газар”-агентлаг байгуулагдснаас хойш салбарынхантайгаа уулзав уу?**

Агентлаг байгуулагдснаас хойш

Усны салбарын сайд, дарга нар эрдэмтэд, докторуудтай уулзаж ярилцсан. Усны салбарын ахмадууд, үе үеийнхний үг яриа, үзэл бодлыг сонсож, ажилдаа тусгаж байна. Бас усны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзаж ярилцан, санаа бодлыг нь сонсож байна. Ус гаргадаг, өрөмдлөг хийдэг, усны барилга байгууламж барьдаг бүхий л байгууллагууд энд хамрагдсан даа.

Монгол улсын ус ашиглалтын балансыг тооцож гаргалаа, Газрын доорх усны мониторингийн сүлжээний хяналт, удирдлагын портал хөгжүүлэлтийг хийж байна.

**-Сав газрын захиргаатай бол өдөр тутам удирдлагаар хангаж байна уу?**

-Тийм ээ. Цахимаар харьцаж, онлайн хурал уулзалтуудыг хийж байна. Тэдэндээ сар тутам чиглэл өгөөд өдөр тутам харьцаа холбоотой ажиллаж байна.

**-Устай холбоогүй, хамааралгүй салбар, аж ахуйн нэгж нэг ч байхгүй. Тэгэхлээр та бүхний ажил их өргөн хүртээмжтэй ажил юм даа?**

-Тийм шүү. Уснаас ангид айл өрх, албан байгууллага, хүн амьтан, хөрс шороо гэж үгүй болохоор бидний ажил бүхэнд хамаатай. Энэ үүрэг, хариуцлага манай хамт олон маш сайн ойлгож, ажил үүргээ гүйцэтгэдэг гэдгийг хэлэхэд таатай байна.



# ДЭЛХИЙН УСНЫ ӨДРИЙГ ЯАХ ГЭЖ ТЭМДЭГЛЭДЭГ БОЛСОН ЮМ БЭ?

*Усны боловсролын Тойрог Төвийн захирал, Монгол улсын усны барилгын зөвлөх инженер, Доктор Лунтэнгийн Жанчивдоржтой тэмдэглэлт өдрийн тухай, ус хангамжийн нөхцөл, хэрэглээний тухай ярилцсан тэмдэглэлээс сийрүүлж хургаж байна...*



## УС ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙХ НЬ ... ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ ЮМ

Дэлхийн усны өдрийг хэзээнээс яаж тэмдэглэж ирсэн юм бэ гэдгээс эхлэж ярилцая. Өнгөрсөн зууны хөгжлийн хүрэн эдийн засгийн загварыг ногоон болгох ажлыг усны судлагааны дэлхийн арван жилүүдээр эхлэж улмаар НҮБ-аас 1992 онд Ирланд улсын Дублин хотод 113 орны усны мэргэжилтнүүдийн чуулган зохион байгуулж дэлхийн орнуудын “ус хамгаалах, ашиглах Дублины тунхаглал” гаргаж, 1993 оноос жил бүрийн 3-р сарын 22-ныг усны өдөр болгон тэмдэглэх болсон юм. Энэ нь усны хүртээмжийг сайжруулах, ус хамгаалах чиглэлээр НҮБ-ийн байгууллагуудын санаачлагаар хийх болсон нэгдсэн арга хэмжээ л дээ. Амны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангадаагүй байгаа орнуудыг тэргүүлэх чиглэл болгон хамтран ажиллах замаар илүү бат бөх хамтын ажиллагаа, тэгш нийгэм, илүү тайван бөгөөд тогтвортой дэлхийг бий болгож чадна гэж харж жил бүр тодорхой уриан дор тэмдэглэдэг.

Дуулиан шуугиан болгон хурал цуглаан төдийгээр тэмдэглэх биш харин бүтэн жилд хийсэн ажлынхаа алдаа оноог дүгнэх нарийндаа усны судалгааг өргөжүүлэх, хүн амын усны хүртээмжийг сайжруулж стандартын шаардлага хангасан усаар хэргэлэгчдээ хангах, ус хамгаалах ажлын үр дүнг нэгтгэн жил бүр НҮБ-аас усны хөгжлийн дэлхийн тайлан”-г нэгтгэн гаргадаг учиртай. Дэлхийн усны хөгжилд анхаарал татсан асуудлаар тодорхой уриатай жишээлбэл “Цангасан хотыг усаар хангая” гэх юмуу Олон Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Байгууллагын /ЮНЕСКО/ ерөнхий захирал 2019 оны дэлхийн усны өдрийг НҮБ-ийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтдоо хүрч ус хангамжаа шийдвэрлэхийн тулд “Хэнийг ч ардаа орхилгүй амьдарцаагай” гэсэн уриатай орон бүрийн анхаарлыг иргэд нэг бүрийн ус хангамжид төвлөрүүлэх, 2020 оны 3 сарын 22-ныг “Ус ба уур амьсгалын өөрчлөлт”, 2021 оны усны өдрийг “Усны үнэ цэнэ” түүнийг хэрэглээний салбаруудаар үнэлэх уриатайгаар

зохион байгуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс хуурайшилт болж цэнгэг усны нөөц хомсдон, хүний усны хүртээмж хязгаарлагдах, үер гамшиг нүүрлэх, усны нөөц бохирдох эрсдлийг бууруулах зэргээр хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлэхэд анхаарал тавих ёстой юм. Ус бол уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, сааруулах, дасан зохицоход өөр орлуулах зүйлгүй хэрэгцээ шүү дээ. Манай орны зарим суманд усны хүртээмж сайжраагүй, стандартын шаардлага хангаагүй ус ууж байгаа, бүр хүнд металын бохирдолтой ус хүртдэг хүмүүс бий шүү дээ. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрүүл Монгол хүн хөгжих, ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, цөлжилт, хуурайшлаас аврах ганц эрдэс бол усны нөөц, түүний хуримтлал болоод байна. Энд л энэ том ажлын агуулга оршиж байгаа гэж хэлэх байна.

Монголын сансрын нисгэгч Ж. Гуррагчаа сансарт нисч ирээд бидний оршин байгаа дэлхий ямар жижигхэн, ямар үзэсгэлэнтэй, яагаад монголын ухаант ард түмэн уяхан замбуутив гэж нэрлэсэн юм бол гэж ярьж, хайрлан хамгаалахыг уриалж байсныг санаж байна. Усыг хамгаалах, зохистой ашиглах хэрэгтэй. Энэ цэнхэр гаригийн усны эргэлтийн нөлөөгөөр Монголын өндөрлөг хур бороо бага ялангуяа Хээр, Говийн ирээдүй уснаас л хамаарч бороо бага орсон жил ган болж мал аж ахуйн үйлдвэрлэлд ихээхэн бэрхшээл учруулдаг. Бүр 1918 онд Майскийн бичсэн “дэлхийд од болон гялалзах” тэр л газрын хэвлийн баялагаа ашиглах усаа татах, эрүүл хүнс тэжээл бэлтгэх газар тариаланг тэтгэх ус хэрэгтэй байна. Иймээс бидэнд хийх ажил их байна.

Усны эргэлтийн хуурай мөчлөгт үл сөхрөх ус хангамжийн хар хайрцагны бодлоготой болж гэмээнэ итгэлтэй урагшлах болно. Гадаргын усны хуримтлал үүсгэх замаар ус хангамжийн бодлогод өөрчлөлт оруулах олон зорилтуудыг өнөөдөр ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Усжуулагчид 30 гаруй том, дунд хэмжээтэй нуур цөөрөм усан сан байгуулж байсан туршлагатай. Гадаргын ус чинь зөвхөн хүнийг биш, ан амьтан, ургамал модыг усаар хангаад зогсохгүй байгалийн тэнцвэрт байдлын хамгийн гол зохицуулагч экосистемийн үйлчилгээ үзүүлдэг суурь баялаг юм. Гадаргын урсацгүй хуурай бүсэд тэжээмжгүй гүний ус ашиглах довтолгоог яагаад өөгшүүлээд байдаг юм бэ? гэдгийн учрыг бид олохгүй л бололтой өнөөгийн энэ төрх аймшигтай биш гэж үү.

“Ус нөөцийн хувьд хангалттай, хангамж нь хүртээмжтэй, үнийн хувьд боломжийн чанарын хувьд шаардлага хангасан байх” Дублины зарчмыг баримтлах, хүртээмж талаас харах нь манай улсын өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байгаа юм. Манай улсын нийт хүн амын тэн хагас хүртээмж муу, стандартын шаардлага хангасан ус ууж чадахгүй байгаа шүү дээ.

НҮБ-ийн дарга асан Кофи Анан “Ус хүртээмжтэй байх нь хүний үндсэн хэрэгцээ, хүний үндсэн эрх юм” гэж зарлаж байсныг санаж байна. Мянганы хөгжлийн зорилгод чиглэсэн бодлого явуулахыг уриалж олон дэмжлэг үзүүлсний нэг энэ арга хэмжээ байгаа юм. Уг нь энэ чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дүгнэн тэмдэглэх учиртай юм. Бид ч хурал хийж тэмдэглэдэг болж байна.

### УСНЫ ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ БОЛ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЭЛ БАЙСААР ИРСЭН

Хуурайших нь чийгшихээс, урших нь тундаснаасаа давсан Зүүн Хойд Азийн өндөрлөгт, эх газрын нэн эрс тэс, хахир ширүүн уур амьсгал дунд Монголчууд бид тэмцэж амьдарсаар иржээ. Газар тэнгэрийн савслагад ус эрэн бидэрч бороо хур гуйн уул усандаа мөргөж, судар ном туурвиж ирсэн ард түмэн монголоос өөр олон байдаг уу. Тийм ээ. Усны төлөө л тэмцэж амьдрах нь хуурай бүсийн газарзүйн хязгаарлалт байсаар иржээ.

Хүн эрүүл саруул өсөж, хөгжихийн үндэс цэвэр ус ууж, эрүүл мэндэд хоргүй хүнс, тэжээлийн зүйл хэрэглэх учиртай. Гэтэл манай орны ялангуяа газрын доорх усны чанар стандартын шаардлага хангахгүй эрдэжилт өндөртэй, хатуулаг ихтэй байх нь газрын доорх усыг тэжээх борооны ус, уст давхаргын чулуулгийн шинж чанартай холбоотой байдаг. Борооны ус газрын доорх усыг тэжээх хэмжээнд ордоггүйтэй их холбоотой.

Олон жилийн эрэл хайгуулын ажлын дүнд цэнгэг ус олох нөхцөл тааруу газруудад амны усыг ус сайтай газраас савлан зөөх, эсвэл амны усыг цэнгэжүүлэн, зөөлрүүлэх жижиг үйлдвэр байгуулж бусад хэрэглээндээ олсон усаа ашиглах нь зүйтэй.

Ирээдүйн олон салбарын хөгжлийн суурь болгож гадагш урсан одож байгаа усны зохих хувийг яндан хоолойгоор татаж хөдөөгийн хөдөлмөрчдийг, сумын төвийг цэвэр усаар хангах хэрэгтэй

Манай орны говь, тал хээрт гадаргын ус ховор, зөвхөн газрын доорх усаар л амьдарсаар ирсэн. Монголын Хээр, Говийн бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн амьдрал “ботгоны нүд” шиг булаг, шандыг бараадан нүүдэл хийж, усны төлөө тэмцэл нь амьдралын төлөө тэмцэл байсаар ирсэн шүү дээ. Уг нь үндсэн хуулинд заасны дагуу ус төрийн өмч, төр засаг, ус хангамжийг шийдэх учиртайг олон улсын тунхаг бичигт заасан байдаг. Бороо хуртай, усны нөөц ихтэй оронд сураад ирсэн хүмүүс говь газар дор далай байдаг, гол урсдаг мэтээр ярьж туйлшрах нь байдаг. Гэвч тэр бол домог бөгөөд олон сая жилийн өмнө цэлэлзэж байсан далайн ёроол чинь манай хээр говь юм шүү дээ. Би ХХААХҮЯ-ны Усны аж ахуйг удирдах газрын даргын алба хашиж байхдаа Монголын өндөрлөгийн байршлын өвөрмөц онцлог хийгээд монгол ахуйн ус хэрэглээ, ашиглалтыг гадаад улсуудын ус хангамжийн бодлого хэрэгжилттэй харьцуулан судласан олон жилийн туршлагадаа тулгуурлан өргөн дэлгэр нутагт газрын хэвлийн усны хайгуулын шинэ арга эрэлхийлж Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн боловсруулж нэвтрүүлж эхэлж байсан усны байгалийн изотопын найрлагыг судлах төсөлд хамрагдах, залуу судлаачдыг сургах ажлыг эхлүүлснээс хойш Техникийн хамтын ажиллагааны 3, Ази номхон далайн бүсийн хамтын

ажиллагааны гэрээний 3 төсөл хэрэгжүүлж, 14 хүнийг урт богино хугацааны сургалтад хамруулснаас гадна олон жил хөөцөлдсөний ачаар 2017 оноос изотопын лабораторийн лазер-тоног төхөөрөмж хүлээн авч лаборатори байгуулж эх орондоо судалгаа хийж эхлээд байна. Дэлхий дээрх усны эргэлтийн үзэгдлийн ганц тодорхойлогч нь байгалийн усны молекул дахь ус төрөгч ба хүчилтөрөгчийн изотоп болохыг нээснээс хойш судалгааны шинэ арга 1961 онд гарсан юм. Олон жилийн судалгааны үр дүнд хуурай, ус татруу манай орны онцлогийг гадаад орны нөхцөлтэй харьцуулан дүгнэж газрын доорх усны тэжээмж тааруу бүс нутгийн судалгаанд усны изотопын техник, технологи нэврүүлэхэд 30 гаруй жилийн хөдөлмөрөө зарцуулжээ. Экологийн чиг баримжаатай байгалийн нөөц ашиглах, ялангуяа Говийн дарагдмал усны гарал үүслийн талаар онолын судалгаа хийж, тэжээлгүй газрын хэвлийн усыг зохистой ашиглах асуудлаар харьцуулсан сонирхолтой судалгаа хийж, олон залуусыг дагалдуулан сургаж хамтарсан бүтээл туурвисан байна. Манай Дундговийн Олгойн говийн ус 35000 жил, Бор хөөврийн говь 18500жил, Замын үүдийнх 29500жил, Балгасын улаан нуурын савын ус 20500 жилийн өмнөөс хадгалагдсан эртний, дарагдмал устайгаараа Хангайн голын тэжээмжит уст давхаргаас ялгаатай. Энэхүү Монголын говийн газрын доорх усны хөдөлгөөн, тэжээмжийн зүй тогтлыг усны байгалийн изотопын судалгааны үр дүнд дарагдмал ус эртний устай толбо нутаг байгааг илрүүлж, газар доорх усны тэжээмж олон жилийн дундаж тунадасны 0.7-1.7 мм/жил болохыг тогтоолоо.

### НӨХӨН СЭРГЭХ БОЛОМЖООС ХЭТРҮҮЛЭХГҮЙ АШИГЛАХ НЬ ЧУХАЛ

Монгол орны газарзүйн байршил, далайн түвшнээс өндөрт оршихуй, жилийн тэн хагаст хөлдүү газар, цаг агаарын нэн эрс тэс нөхцөл гэх зэрэг нь мянга мянган жилд монголчуудын амьдрал, ахуйг нөхцөлдүүлснийг мартаж болохгүй. Магадгүй байгаль цаг уурын энэ өгөгдөл монгол улс, монголчуудыг авч үлдсэн ч байх. Дэлхийн дундажаар 860 мм тунадас ордог байхад Монголын өндөрлөгт дундажаар 250мм, харин Говь цөлд 47мм тунадас унадаг, түүний ашигтай хэмжээгээр газрын доорх ус нэн бага тэжээгдэж байдаг юм. Энэ том хуурай гандуу нутаг дэвсгэрт усны нөөц бүрдэх саринах зүй тогтол, горим бүс нутгийн улс орнуудаас их ялгаатай болохоор судалгаа шинжилгээ, мониторингийн ажлыг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж үр дүнг шийдвэр гаргах түвшинд ашиглах шаардлагатай байгаа юм. ОХУ-д 1200-250мм, БНХАУ-д 2000-50мм, Солонгост 1300-600мм Японд 1600-1200 мм тунадас бууж усны нөөцийг бүрдүүлж байгааг 250мм тунадастай харьцуулахад харин ч тэнцвэргүй харагдаж байгаа биз. Тэгээд тэдгээр ус ихтэй орны арга, туршлагаар ус ашиглаж, амьдралаа гээд зүтгэх нь зөв үү. 20000-45000 жилийн настай эртний, дарагдмал усаа ховх соруулан дуусгах нь сайн зүйл биш. Мөн Хойд мөсөн далай, Номхон дөлгөөн гадаад далай, азийн гадагш урсацгүй ай савын огтлолцлолын цэг манай оронд оршдог, зуны борооны уснаас бүрдсэн урсацын 63% ОХУ, БНХАУ-ын нутгаар дамжин гадаад далайд урсаад гарчихдаг онцлогтой. Монгол орны усны нөөцийн 1.93% эзлэх газрын доорх усаар нийгэм, эдийн засгийн жилийн



хэрэглээний бараг 80%-ийг хангаж байна. Энэ нь гадаргын усны нөөцийн нэн жигд бус тархалт, манай орны өвлийн хөлдүү зэрэг нөхцлөөр тодорхойлогдох боловч хүн ам, үйлдвэр хөдөө аж ахуй, уул уурхайн бүхийл хэрэгцээг газрын доорх усаар хангах бэлэнчлэх явцуу бодлоготой их холбоотой.

Олон зууны туршид говийн

нүүдлийн мал аж ахуйн усны хэрэгцээг борооны усны тэжээмжит ардын гүехэн худгаар шийдвэрлэж ирсэн байдаг. Харин их ус хэрэглэдэг үйлдвэр аж ахуйн усны нөөцийг хайгуулаар тогтоож ашиглах зөвшөөрөл олгодог дүрэм үйлчилж байгаа юм. Энэ дүрмийг өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх заавар, журам боловсруулах шаардага тавигдаж байгаа юм.

Харин хуурай, гандуу нутгийн хөдөлмөрчид усыг ахуйдаа нэн хязгаарлалттай хэрэглэдэгийг өөрчилж хүний эрх, хүний биологийн горимыг нөхцөлдүүлэх хэмжээнд хүртэл дэмжиж, эрүүл монгол хүн өсгөх шаардлага бас бий. Амны усаа холоос зөөдөг айл ойрхон сайн устны эх үүсвэртэй бол ахуй өөрчлөгднө дөө.

Харин уул уурхайн хөгжил дэвшил говийнхонд хөгжил авчрах гэдэг юу л бол. Говийнхон гэдэг одоогийн энэ үеийхэн биш шүү дээ, хойч үе удамт малчдын залгаа үе бас хамаарна. Өмнөд говийн бүс нутагт тэжээмж багатай эртний, дарагдмал устай цөөн хотгорууд бий. Эрдэс баялаг бий, түүнийг нээж болно, харин тэдгээрийг ашиглах үйлдвэрлэлийн хэрэгсэл болсон усыг олох боломж бараг байхгүй гэж хэлэх байна. Дэлхийн хүн төрлөхтөн техникийн зуунд шилжлээ гэдгийг тунхагласан 1893 он буюу Эйфелийн цамхаг боссоноос хойш технократ үйл ажиллагаа давамгайлж байгалийн баялагийн хэт ашиглалтад суурилан хөгжиж байлаа. 1980 аад оны эхнээс байгалийн нөөцийг түүний нөхөн сэргэх боломжоос хэтрүүлэхгүй ашиглах, олборлосон нөөцийг гүйцэд боловсруулах, хаягдлыг хамгийн бага байлгах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах тухай шинэ үзэл баримтлал гарсан юм/ Г.С.Хачатуров. 1982/. Энэ үзэл баримтлалаар бол жилд 1-3мм тэжээмжтэй газрын доорх усыг ашиглах боломж маш хязгаартай, гэтэл бид ашигласаар л байна.

“Ус бол бидний ирээдүй” уриатай болсон Дэлхийн усны VII форумын нээлтийн үеэр Өмнөд Солонгосын ерөнхийлөгч хэлсэн үгэндээ XXI зууны хүн төрөлхтний хамгийн тулгамдсан асуудлуудын нэг нь ус болохыг “XX зуун хар алтны төлөөх зуун байсан бол XXI зуун цэнхэр алтны төлөөх зуун болно” гэж сануулсан юм.

## ХҮЧИРХЭГ БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ...

Усны салбар техник-технологийн, инженерингийн маш чухал салбар байх учиртай юм. Америкд АНУ-ын Армийн корпус бодлогыг дэргэдэх Усны нөөцийн хүрээлэнгээрээ дамжуулан хэрэгжүүлж, ус ашиглагчдад заавар, журам, гарын авлагаар хангаж томоохон боомт усан санг үлгэр жишээ ашиглаж хамгаалж байдаг юм. БНУАУ-д дотоод Явдлын яамны харъяа усны удирдах газар ажилладаг, Урд хөршид Усны нөөцийн яам хариуцдаг байхад БНСУ-д төрийн K-Water гэх хүчирхэг бодлого хэрэгжүүлэлтийн байгууллага ажиллаж байна. Харин Монголд БОАЖЯ-нд газар, 2020 оноос Усны агентлаг зохион байгуулагдлаа. Сав нутгийн захиргаад ажиллаж, ХХААХҮЯ, БХБЯ, ЭХЯ, ГХЯ, УУХҮЯ, ЭМЯ-д мэргэжилтнүүд хариуцаж олон толгойт бодлогоор зохицуулж байгаа нэртэй явж байна. Усны салбарын үйлдвэрлэл зогсонг, мэргэжлийн инженерүүд бэлтгэж чадахгүй болжээ. Одоо хүчирхэг үйлдвэрийн баазтай байгууллага өдрийн од шиг гялалзаж, “би чадна” гэх худаг гаргадаг, усны барилга барьдаг компаниуд чанар муутай ус гарган үйлчилдэг систем батжин захиалагчдыг хохироож богино настай худаг, усны барилга байгууламж барьж байна. Одоогийн байдлаар 40 гаруй сумын төвийн усны нөөц бүрэн тогтоогдоогүй, 70 гаруй сумын иргэд эрдэсжилттэй хатуулагтай ус ууж байна. Техник технологийн бодлогогүй, хяналтын систем байхгүй учраас яамд нэг хоёр хүн тоо бүртгэл хариуцан сууж “усны менежмент” хийж байна даа.

## ГАЗРЫН ДООРХ УСНЫ ХЭРЭГЛЭЭГ ХЯЗГААРЛАЖ...

Хангай нутагт урсаж гадаадад урсан гардаг томоохон гол мөрний урсацын хэсгийг Говь руу татах боломж бололцоо бий юу? гэж хүмүүс их асуудаг.

Гадаргын ус элбэг газраас ус тээвэрлэх яндан хоолойн олон мянган км систем байгуулж ашиглаж байгаа орнууд дэлхийд олон бий. Энэ бол үйлдвэрлэл практикт нэвтэрсэн техникийн шийдэл шүү дээ. Манай оронд 1960 оноос Туул голын хөндийгээс 80 км ус хангамжийн хоолой, 1978 онд Сэлэнгэ-Эрдэнэтийн 64 км 4 шатлалт насос станцтай шугам, Увс аймгийн Хархираа голын усыг 46 км яндан хоолойгоор татаж 2000 га услагааны бороожуулах машиныг автоматаар ажиллуулах хоолойн систем, Дундговийн төвийн ус хангамжийн шийдвэрлэх Олгойн говийн 29 км хоолой, Хэнтий аймгийн Дархан сумаас Бор өндөрийн уурхай руу 30 км хоолой гэх мэт урсацын хэсгийг шилжүүлэн ашиглах төслүүд хэрэгжиж байгаа билээ. БНХАУ хойт бүс нутгийн хөгжлийн хязгаарлах хүчин зүйл усны нөөцийг бий болгох шийдвэр гаргаж, алдарт Хөх мөрнөөс Шар мөрний урсацыг тэтгэх, зарим хотын ус хангамжийг шийдэх ус тээвэрлэн дамжуулах байгууламжуудыг барьж дуусч байна. Энэ төсөл баруун шугам/1000км/, Дайчинкоу-Бээжингийн дунд шугам/ ёроолоороо 9 м өргөн, 1270 км суваг/, Тайху нуур-Нанжин хотын дорнодын ус дамжуулах 1156 км хоолой гэсэн гурван чиглэлээр урсацын хэсгийг шилжүүлж байна. 1970 аад оны сүүлээр Дорноговь аймгийн Мандах сумын нутагт Цагаанцавын зэс молибдений орд нээгдэн усаар хангах арга хэмжээний хүрээнд Унгар улсын

мэргэжлийн байгууллага Хэрлэн голын урсацын хэсгээс замд дайралдсан хот суурин, услагаатай талбайд ус өгөх цогц ажлын ТЭЗҮ боловсруулсан байдаг.

Монголын Засгийн газрын 2010 оны 6-р сарын 16-ны өдрийн 151-р тоот тогтоолоор баталсан “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Усны үндэсний төв Пристиж групп “Хэрлэн-Говь” ба “Орхон-Говь” гэсэн төслүүдийг боловсруулж Хээр говийн бүсийн усны чанар муутай аймаг, сумын хөдөлмөрчдийг усаар хангах, уул уурхайн үйлдвэрийн ус хангамжийг шийдвэрлэх санал бэлтгэсэн байна. Тэдгээр том мега төслүүдийн хамрах бүс нутаг болон ус дамжуулах шугам хоолойн байршлыг харвал маш олон асуудлыг шийдэх газрын доорх усны хэрэглээг хязгаарлаж гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх төсөл болсон байдаг. Энэ бол өнөөдөр биш гэхэд заавал хийгдэх л ажил.

### УСНЫ БОЛОВСРОЛЫГ БҮХ НИЙТИЙН ҮЙЛС БОЛГОХ ХЭРЭГТЭЙ

Монголчууд бид бас их туйлширдаг ард түмэн юм даа. Усны зохистой хэрэглээний тухай, хүн, амьд амьтан, ургамалд ус дутагдвал ямар хор холбогдолтой болдог тухай, хүний эрх усны хүртээмжийг хэвийн болгох тухай ажил хийж, сурталчилж, зохистой хэрэглээг хэвшүүлэх тухай асуудал гараад ирэхээр хэмнэ бага хэрэглэ гээд л туйлшраад байх юм. Засаг төр нь үүргээ биелүүлж, эрүүл мэндэд халгүй, стандартын шаардлага хангасан усаар хангах, иргэд усаа зохистой ашиглах, хамгаалах, үйлдвэр аж ахуйн газрууд хэмнэлтэй технологи нэвтрүүлэх, эргэлтийн ус ашиглах гэх мэтээр шинжлэх ухааны үндэслэлтэй зураг төслөөр техник-технологийн бодлогыг тууштай нэврүүлэх л үүрэгтэй. Зураг төсөлгүй, хоцрогдсон технологиор оролдогсод мөн ч олон болж дээ.

Усны боловсролын тухай дунд сургуулийн хөтөлбөрт оруулах замаар хүүхдийг багаас нь усны ач холбогдол, ашиг тусыг мэрүүлэхэд л хожим зардал гарган үглэн дуулахгүй болно шүү дээ. Зуслан гэж нэг эзгүй хоосон хашаатай байшин хот суурин газрын хаяанд олон жил зүүгдэж байна даа. Зуслан, хаус барьчихаад хашаандаа мод тарьж цэцэг ургуулан хүүхэд залуусаа байгальд ойртуулж өсгөмөөр байна. Тэгэхгүй юм аа. Цэцэрлэг, бага ангид байхаас нь яаж зөв монгол хүн болох, байгальтайгаа хэрхэн шүтэлцэн амьдрах ухааныг аав ээж, ах эгчийн дуриалаар олгох хэрэгтэй дээ. Цэцэрлэг, дунд сургуулийн сурагчдаар дамжуулан усны боловсролыг бүх нийтийн үйлс болгож тэд устай харьцаж, усанд орж, усанд сэлж сурч, хэрэв болгоомжгүй оролдвол энддэг гэдгийг мэдүүлэх шаардлагатай. Зарим сайн удирдагчтай сургууль усан бассейн хичээлийн байр барьж байна. Устай буруу харьцаж гал усны гашуун зовлонг ойлгож мэдээгүй олон хүн усанд нас барж байна.

### УСНЫ НӨӨЦӨӨ ОНОВЧТОЙ АШИГЛАХ НЬ Л ЧУХАЛ

Монгол орон усныхаа хэрэгцээний 90 орчим хувийг газрын доорх усны нөөцөөр, 10 орчим хувийг гадаргын усны нөөцөөр хангадаг гэсэн баримжаалсан тооцоо байдаг. Усны гол хэрэглэгч нь хот, аймаг, сумын төвийн хүн амын ус хангамж, үйлдвэр, уул уурхай, усалгаатай

тариалан болон мал аж ахуй юм. Одоогийн байдлаар манай улсын хүн амын ундны усны хэрэглээ жилд 75 сая, ахуй үйлчилгээний салбар 12 сая, үйлдвэр 6-7 сая, эрчим хүч 45 сая, уул уурхай 80-90 сая, барилга 136 сая, мал аж ахуй 95 сая, газар тариалан 158-160 сая м3 ус хэрэглэдэг, улсын хэмжээнд нийтдээ 700 сая гаруй м3 ус хэрэглэдэг, энэ тоо 2022 оны үед 830-840 сая болно гэсэн тойм тооцоо ч бий.

Газарзүйн байршил, тунадасны хэмжээ, хуваарилалтаас шалтгаалж газрын доорх усны нөөц, бүрдэх үйл явц хязгаарлагдмал ялангуяа нийт нутаг дэвсгэрийн 68 хувийг эзлэн оршдог гандуу, хуурай бүс нутгийн газрын доорх ус нэн бага тэжээмжтэй байгаа нь сүүлийн үеийн судалгааны мэдээллээс тодорхой харагдаж байна. Хуурай бүсэд ажиллаж байгаа уул уурхайн ордууд эртний дарагдмал ус ашиглаж соруулсан усны орон зайг нөхөх алхам хийх, байгаль орчныг хамгаалах үйлсэд ахиц гаргах хэрэгтэй

Дэлхийн гурван том ай савын огтолцолд оршдогоос бүрэлдэн бий болсон багахан усны нөөцөө улсын нийгмийн болон эдийн засгийн хөгжилд оновчтой ашиглаж, байгалийн зүй тогтол, унаган төрхийг хадгалан хамгаалахад чиглэсэн бодлогыг бүх нийтээрээ ухамсарлаж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай л гэж хэлье дээ.

Би, миний үеийн хүүхдүүдийн замаар бужигнаж, тэр үеийн хөдөөгийн уул талаар соёлын үрийг таригч гоё, багш нарыг бишрэн, гайхаж дууриаж явсан хөдөөний хүү 10-р ангиа төгсөөд усны инженерийн мэргэжлээр Их сургуульд суралцах хуваарь авсан байлаа. Тэр үеийн оюутны амьдрал сайхан, гэгээлэг хамгийн хөгжилтэй байсан, цалин авна сайн онцын нэмэгдлийг өөртөө үлдээж тэтгэлэгээ аав ээждээ нэмэрлэнэ, билгийн нүдийг нээж, нарийн мэргэжлийн чиглэл авч, ертөнцтэй танилцах бололцоо олгосон усны инженер мэргэжил намайг энэ ертөнцийг бага ч болов танин мэдэх суурь байсан, Би бас олон оронд дахин дахин явж усны салбарын хөгжил цэцэглэлт, хүний хөгжлийг нүдээр үзэж биширч явсан нэгэн. Сургууль төгссөнөөс хойш 48 жил ус эрэх хайх, олборлох, хэрэглэгчдийг усаар хангах усны нөөцийн хайгуул судалгаа, зураг төсөл, эрдэм шинжилгээ хийгээд усны барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, бэлчээр усжуулах, услалтын байгууламж байгуулах зэрэг салбарын олон талт ажилд хамтран зүтгэгчдийн хамт ажилласан. Усны ажил багийн ажил шүү дээ. Ус нь хүн, байгаль, нийгмийн харилцааны бүхий салбарт хэрэглэгддэг стратегийн нөөц баялаг, үйлдвэрлэлийн хэрэгсэл болохоор бүх юм устай, миний мэргэжилтэй холбогддог учир тэдэнд бид туслаж явсан. 1970-1990 он бол малчид, мал аж ахуйн ус хангамжид томоохон өөрчлөлт гарсан үе бөгөөд түүний инерцээр одоо хүрч байгаа юм. Тэр үед байгуулсан бүтээн байгуулалтаа эвдэж, устгаж дуусч байна.

Том нутаг дэвсгэртэй цөөн хүн амтай, хуурай газрын арал орон Монголд аль ч үед амьдралын төлөө тэмцэл усны төлөө тэмцэл байжээ. Гэвч дэлхийн усны нөөц ихтэй орныг дуурайж усыг тоохгүй бүтээн байгуулалт хийх гэж оролдсоноос байгаль орчиндоо ихээхэн гай тарьж байна даа.

## ТУУЛ ГОЛД ХАЯГДАЛ УС НИЙЛҮҮЛСНИЙ УЛМААС ИХ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ ҮҮССЭН



“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь эрчим хүч, дулаан үйлдвэрлэх технологийн дамжилгаас гарсан үнснийг усаар зайлуулж, 2 шатлал бүхий тунгаах сангаар дамжуулан тунгааж, технологийн хэрэгцээнд эргүүлэн ашигладаг. Станцын ачаалал нэмэгдэж, бүрэн хүчин чадлаар ажиллаж байгаагийн улмаас хаягдлын сангийн усны түвшин огцом нэмэгдэж, хаягдлын сан болон тунгаах сангийн далан сэтрэх эрсдэл үүсч, ослын нөхцөл байдал үүссэний улмаас 02 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд тунгаах санд хуримтлагдсан хаягдал усыг Туул голд нийлүүлсэн байна.

Хаягдал ус зөвшөөрөлгүй байгальд нийлүүлсэн зөрчлийн дагуу Усны газар, Туул голын сав газрын захиргаа, нийслэлийн Байгаль орчны газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хамтарсан шалтгалт хийж, хаягдал ус хаяхыг зогсоож, тунгаах сангийн илүүдэл ус хаях ослын шугаманд хаалт суурилуулж, илүүдэл усыг хаягдлын санд буцаан шахах, эргэлтийн системд оруулж, Эрчим хүчний ямаар дамжуулан тус станцын ачааллыг бууруулах арга хэмжээг авсан. 2020 онд шинээр байгуулсан хаягдлын санг удахгүй ашиглаж эхлэх тул дахин хаягдал усыг байгальд нийлүүлэх эрсдэл үүсэхгүй бөгөөд тунгаах сангийн

илүүдэл усны аваарын шугамыг авах шаардлага тавьсан.

Тус станц нь үйл ажиллагаагаа зогсоох боломжгүй Улсын онцгой объект хэдий ч үүссэн эрсдлийг урьдчилан тооцоолж, холбогдох байгууллагуудад мэдэгдэхгүйгээр хаягдал усаа байгальд нийлүүлсэн нь Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг зөрчсөн. Үүний улмаас 780 орчим м<sup>3</sup> хаягдал усыг Туул голд нийлүүлж, 37.8 га талбайг хамарч, 1.7 км зайнд үнсний лаг хуримтлагдсан байна. Туул голд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ, бохирдлын үзүүлэлтээс шалтгаалан

ус бохирдуулсны нөхөн төлбөр, усны нөөц, усны сан бүхий газарт үзүүлсэн хохирлын нөхөн төлбөр төлөх, Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль төлөх нөхцөл үүссэн.

Мөн хаягдал ус нийлүүлсний улмаас Туул голын салаанд хуримтлагдсан үнсний лаг, бохирдлыг цэвэрлэх, голын голдирлыг хэвийн байдалд оруулах ажлыг холбогдох дүрэм, журмын дагуу станц өөрийн зардлаар гүйцэтгэсэн.

Иймд ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаандаа Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласнаар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, нөгөө талаас зөрчлийн улмаас их хэмжээний нөхөн төлбөр төлөх, улмаар санхүүгийн эрсдэлд орох нөхцөл үүсч болзошгүйг анхаарна уу.

Байгаль, эх дэлхий, амьдралыг тэтгэгч амин рашаан, цэнхэр алтаа хамтдаа хайрлан хамгаалцгаая.

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГАА





Өмнөх нийгмийн үед аль ч салбар, байгууллагын үүдэнд “Хүндэт самбар” гэж байв даа. Ажил үйлсээрээ цойлон шалгарсан хүмүүсийнхээ зураг хөргийг тийнхүү тавьж, алдаршуулан, хамт олон нь бахархан, шилдэг тэргүүний тэдгээр хүмүүсээс үлгэр дууриал авдаг, хошуучлан манлайлагчдынхаа жишигээр ажиллаж бүтээхийг эрмэлздэг байсан билээ. Манай “Цэнхэр алт” сонин бас салбарынхаа шилдгүүдийн тухай цувралаар нийтэлж, ажил үйлс, амжилт бүтээлийг нь сурталчлан таниулах “ШИЛДГҮҮД” буланг нээж байна. Энэ удаа бид “Хараа Ерөө сав газрын захиргаа”-ны ахлах мэргэжилтэн Л.Галбадрах, “Хар нуур Ховд голын сав газрын захиргаа”-ны дарга Р.Энхсүрэн нарын тухай сурвалжлан нийтэлж байна.

## ЭВЛЭЛИЙН ДАРГААС ИХ УСНЫ САЛБАРЫН “ТОРГОН ЦЭРЭГ” ХҮРТЭЛ.



Лхаажав овогтой Галбадрах нь уг нь Архангай аймгийн Тариат сумын “унага” юм. Тэрбээр тэнд 1961 онд мэндэлжээ. Улмаар сумынхаа бага, дунд сургуулийг дүүргээд 1979 онд ЗСБНХУ-ын Беларусын Чечерск хотод Хөдөө аж ахуйн техник мэргэжлийн сургуулийг трактор-комбайны жолооч мэргэжлээр төгссөн. Архангай аймгийн Төвшрүүлэхийн сангийн аж ахуйд тракторын жолоочоор нэг жил ажиллачихаад армид алба хаахаар гарч өгсөн юм. Цэрэгт очоод тэр Эвлэлийн гялалзсан дарга болов. Галбадрах 1980-1983 онд Хилийн ба Дотоодын цэргийн 0229 дүгээр ангийн 0194 дүгээр тусгай салбарт гялалзсан түрүүч албаа нэр төртэй хаагаад сумандаа ирэв.

Цэргээс ирээд тэр 1983-1987 онд Архангай аймгийн Цэнхэр сумын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн Хорооны нарийн бичгийн дарга, улмаар сумын Захиргаанд зохион байгуулагч, сумын Ардын депутатын хурлын нарийн бичгийн дарга зэрэг алба ажлыг хийсэн.

Түүний ажил үйлс замнал тийнхүү шат шатаар ахиж дээшилж, амжилт бүтээлээр дүүрэн байв. Тэрбээр 1992-1996 онд Цэнхэр сумын Засаг даргын тамгын газрын даргаар ажилласан билээ. Ажилдаа эзэн, мэргэжилдээ мэргэн байхыг хичээхийг мөрдлөг болгодог тэрбээр 1990 онд Шүүх яамны харьяа Хууль цаазны дунд сургуулийг хуульч мэргэжлээр, 2005 онд Шихихутаг хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавраар тус тус төгссөн юм.

Л.Галбадрах Цэнхэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан бөгөөд 2006-2009 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны Хэрэг эрхлэх газарт аж ахуйн эрхлэгчээр ирж ус гэдэг нандин эрдэнэтэй холбогдсон түүхтэй. Улмаар тэр 2009-2012 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтнээр ажиллаж байгаад Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэдэлд шилжсэн,

Устай холбоогүй, уснаас хамааралгүй салбар нэгж, айл өрх, амьтан ургамал ч гэж үгүй билээ. Тийм болохоор энэ салбарынхан ажил мэргэжлээрээ үнэнхүү бахархаж “баярхаж” явдаг биз ээ. Тэрбээр 2012 оны 10 сараас “Монгол-Ус” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын аж ахуйн албаны даргаар ажиллаж байгаад 2014 онд Орхон голын сав газрын Захиргааны даргаар, 2015 онд Хараа-Ерөө голын сав газрын захиргааны даргаар тус тус ажилласан түүхтэй. Улмаар 2016 оноос тус сав газарт ахлах мэргэжилтнээр томилогдон ажиллаж байна.

Эвлэл гэдэг цог хийморь гэрэлтсэн сайхан салбарт ажиллаж байхдаа тэрбээр залуучуудыг хадлан гэжээл бэлтгэх, даваа, зам, харгуй засах, төмс, хүнсний ногоо хураах болон бусад бүтээлч ажлуудад уриалан дуудаж зохион байгуулан оролцож байсан нь тухайн үед сум, нэгдлийн төлөвлөгөөт ажлыг биелүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байсан ажээ..

Усны хэрэг эрхлэх газарт ажиллаж байхдаа байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, ажиллагсдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах талаар идэвхи санаачлагатай ажиллаж байв. Төрийн өмчийн-II байрыг Усны газрын эзэмшилд шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн ба тус байрны өргөтгөлийг хийлгэж 3 давхар болгоход зохих хувь нэмрээ оруулсан юм.

Энэ хугацаанд Усны газар нь өөрийн байртай, машины зогсоолын талбайтай, материаллаг бааз болон ажиллагсадын ажиллах нөхцөл, техник хэрэгсэлийн хангамж сайжирсан байна.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, зөвлөмж, Ерөнхийлөгчийн албан даалгавар, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Усны талаар гарсан Үндэсний хөтөлбөрүүд бусад шийдвэрийн хэрэгжилтийн явцыг графикт хугацаанд нь, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалын биелэлтийг хагас, бүтэн жил тутамд заалт бүрээр нь тооцож Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд явуулж усны чиглэлийн



мэдээллээр холбогдох газруудыг байнга хангаж байв.

Л.Галбадрахын энгэрт “Алтан гадас одон”, Ардын хувьсгалын 90, Их Монгол улс байгуулагдсаны 800,

Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалиуд, Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Байгаль орчны тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, Дархан-Уул аймгийн “Найрамдлын Дархан” тэмдэг гялалзан буй. Тэр бүхэн бол түүний ажил үйлс, амжилт бүтээлийнх нь нотолгоо юм. Төрийн байгууллагад 30 гаруй жил ажилласан, туршлагатай, мэргэшсэн төрийн “торгон цэрэг”-албан хаагч тэрбээр энэ 2021 оны хавар “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор шагнууллаа. Энэ бол усаа дагаж жаргах түмний төлөө зүтгэсэн түүний үйлс бүтээлийн гэрэл гэгээ юм аа.

## ЭНГЭРТЭЭ “АЛТАН ГАДАС” ОДОНТОЙ, СЭТГЭЛДЭЭ ОЛОН ОЛОН ГЭГЭЭН ОДТОЙ УДИРДАГЧ



Эх байгаль, эрдэнэ болсон усны төлөө үйлс бүтээлээ зориулах хувь зохиолтой хүн бол Рэнцэндоржийн Энхсүрэн гэлтэй. Тэрбээр Хар нуур Ховд голын сав газрын захиргааны даргаар найм дахь жилдээ ажиллаж байна. Энхсүрэн 1981-1991 онд Мөст сумын 10 жилийн дунд сургууль төгсөж улмаар 1991-1995 онд МУИС-д суралцан Ус судлалын инженер мэргэжил эзэмшсэн юм. Тэр цагаас хойш байгаль дэлхийнхээ судасны лугшилт, зүрхний цохилтыг

анирдаж яваа юм.

Их сургууль төгсөөд тэр Ховд аймагтаа хуваарилагдан ирсэн. Тэрбээр 1997-2000 онд аймгийнхаа УЦУОШТөвд ус судлалын инженер, 2000-2003 онд аймгийн ЗДТГазарт байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн, 2003-2007 онд УЦУОШТөвд захирал, усны инженерээр ажилласан түүхтэй. Улмаар Жаргалант сумын ЗДТГазарт байгаль орчин хяналтын улсын байцаагчаар ажиллаж эх байгалийн төлөө элэг сэтгэлийн гүнээс өнөөг хүртэл зүтгэж явна.

Энхсүрэн Ховд аймгийн Мөст суманд төрж өссөн, малчин ардын хүүхэд. Малчин хүн гэдэг тэнгэр хангай, гол ус, эх байгальдаа хамгийн ойр байдаг, түүнийг зүрх сэтгэлээсээ хайрладаг улс хойно, тэр л “гени” нь үр хүүхэд нь удамших нь дамжиггүй. Тэрбээр 2012 оны хавраас Сум дундын ойн ангийн дарга, инженерээр, жилийн дараа БОАЖГазарт ахлах мэргэжилтнээр ажилласан. Улмаар 2013 оны зунаас Хар нуур Ховд голын сав газрын захиргааны даргаар

томилогдон өнөөг хүртэл ажиллаж байна. Энхсүрэн бол байгаль орчны салбарт 24 дэхь жилдээ ажиллаж байгаа туршлагатай, шилдэг удирдагчийн нэг юм.

Тэрбээр 2003 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагаар мэргэшүүлэх 3 сарын сургалт, Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Японы засгийн газраас хандивласан гар насосыг инженерийн хийцтэй худганд суурилуулах 14 хоногийн сургалт, Байгаль орчны яам Герман улсын Усны газартай хамтран зохион байгуулсан гадаргын ус цуглуулах хуримтлуулах газар тариаланд ашиглах 21 хоногийн сургалтыг тус тус дүүргэсэн.

Ажиллах хугацаандаа ус судлалын 7 харуулын урсацыг амжилттай тооцоолж жил бүр ус судлалын секторт хүлээлгэн өгч, ард иргэдийг цаг агаарын үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг амжилттай удирдан чадварлаг зохион байгуулж Ховд дахь синоптикийн салбар 2004 онд Улсын тэргүүний салбар болж байсан. Мөн Ховдын УЦУОШТөвд анх Байгаль орчны шинжилгээний лабораторийн шавыг тавьж тус лаборатори нь өнөөдөр хөрс, ус, агаарын иж бүрэн шинжилгээг хийж Ховд хотын иргэдийн амьдрах аятай таатай нөхцлийг бүрдүүлэн

цөлжилттэй тэмцэх элсний нүүдлийг сааруулах зорилгоор Нисэх буудлын чиглэлийн хар зам дагуу МУ-ын Байгаль орчны гавъяат Д.Цэндсүрэнтэй хамтран 4 км-т 10000ш Улиас, Бургасны суулгацыг Зэрэг, Булган, Эрдэнэбүрэн сумуудад ойн зурвас байгуулсан нь өнөөдөр иргэдийн талархал хүлээж байна. Мөн инженерийн хийцтэй 30 худгууд дээр Undia-2 гар насос суурилуулсан нь зах зээлийн шуурганаар үрэн таран болсон бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гол хөшүүрэг болсон юм. Буянт голын ай сав дагуу түгээмэл тархацтай хууль бус олборлож буй үйл ажиллагааг таслан зогсоож хайрганы карьеруудыг голын онцгой хамгаалалтын бүсээс гаргасан. Бутлаг ургамал болох харгана бургасыг түлшинд хэрэглэхийг зогсоож ажилласан нь бас нэг ажлын томоохон үзүүлэлт юм. Гар аргаар хууль бус алт олборлогчдын үйл ажиллагаатай хатуу тэмцэн иргэдэд сургалт сурталчилгаа хийснээр эерэг үр дүн авч ирж байсныг дурдахгүй байхын аргагүй юм.

Тус сав газрын захиргааны даргаар сүүлийн жилүүдэд ажиллах хугацаандаа балансын нэгжид хамаарах баруун 5 аймгийн 29 суманд хүрч ажиллаж Байгаль орчны багц хууль, Усны тухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэргэжилтийг онцгой анхаарч сав газрын голуудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, жилд 20-25 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргаж ус ашигласны төлбөрийг аймаг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхэд ололттой ажилласан төдийгүй усны зүй зохистой хэрэглээг бий болгох зорилгоор тоолууржуулалтын ажлыг амжилттай зохион байгуулж албан байгууллага аж ахуйн нэгжийг 86%-д хүргэжээ. Санхүүгийн сахилга батыг хатуу сахиж сүүлийн 8 жил нэг ч төгрөгний өр авлагагүй ажилласан болно. МЖДЭЧДСудалгааны төвөөс явуулсан судалгаагаар тус байгууллага нь Монгол орны хэмжээнд Шилдэг-50 байгууллагын нэгээр шалгарч удирдлага нь жил дараалан шилдэг менежерээр шалгарсан нь энэ баг хамт олныг төдийгүй удирлагын чадвартайг харуулж байна.



Анх удаа баруун бүсэд усны сан бүхий газрыг хазаарлах хамгаалалтанд авах хамгаалалтын бүс тогтоох ажлыг эхлүүлж Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал, ИТХурлын тэргүүлэгчдээр хэлэлцүүлж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит 8-р хуралдаанаар Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох тухай 8/11 тогтоолыг батлуулж, гол мөрний урсац бүрэлдэх эх усны сан бүхий 1000000/нэг сая/-гаруйтай талбайг орон нутгийн хамгаалалтанд авсан нь туршлага болохуйц том ажил болсон. Энэхүү туршлагыг Увс, Завхан, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад нэвтрүүлсэн.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч Ховд Баян-Өлгий аймгуудад сургалт зохион байгуулж 400 гаруй ус бохирдуулагч албан байгууллага аж ахуйн нэгжид хаягдал усны дүгнэлт гаргаад байна.

Сав газрын балансын нэгжид хамрагдах Баян-Өлгий /100000 гаруй хүн амтай/ аймагт сар бүр хүрч ажиллан Усны асуудлаар аймаг сум орон нутгийн Удирдлага, ИТХурлын төлөөлөгчид, холбогдох мэргэжилтнүүдийг тогтмол мэдээ мэдээллээр хангаж, хууль бусаар олборлосон хайрганы карьер, энгийн гар худаг, хогийн цэг, уурын зуух, газар олголт, голын голдирол өөрчилсөн зэрэг асуудлуудаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хандаж зөрчлийг арилгуулж байлаа.

Тус сав газрын захиргааны дарга Р.Энхсүрэнгийн 23 жил Байгаль орчны салбарт хоёргүй сэтгэлээр зүтгэж олон сайхан бахдам амжилт гаргасныг аймаг орон нутаг өндрөөр үнэлж 2017 оны Аймгийн Хөдөө аж ахуй, Байгаль орчны салбарын "Алдартан"-аар тодруусан ажээ.

Ховд аймгийн төсвийн захирагчийн 255 байгууллагаас 2014, 2015, 2016 онуудад санхүүгийн үйл ажиллагаагаараа НББОУСтандартыг хангаж шилдэг 10 байгууллагын нэгээр шалгарч Монгол улсын ерөнхий аудитор Д.Хүрэлбаатарын гарын үсэгтэй "ИТГЭМЖЛЭЛ"-г аймгийн Төрийн аудитын газраас гардан авч байв.

Хар нуур Ховд голын сав газрын захиргааг өнөөдөр 7 мэргэжилтэн, жолооч, нягтлан бодогч, үйлчлэгч гэсэн 11 орон тоотой чадварлаг сайн баг бүрдүүлж үйл ажиллагаа явуулж байна. Атгасан шагай шиг баг хамт олноо удирдсан шиг удирдан залж, улс орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн шиг биелүүлж яваа түүний хөдөлмөрийг төр засаг өндрөөр үнэлэн саяхан төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагналаа. Энгэртээ алтан гадас одонтой, сэтгэлдээ олон олон гэгээн одтой ийм нэг эмэгтэй удирдагч Ховд нутгийнхаа тэнгэр дор ид хийж бүтээж явна. Тэр л олон одны нь гэгээ нутаг усаа улам гэгээн сайхан болгож байдаг аа.

## УС БОЛ АМИНЫ ҮНЭТЭЙ ГЭДГИЙГ ХУУЛЬЧИЛЖ МӨРДДӨГ БАЙСАН

*Усны төлөө үйлс бүтээлээ зориулж, энэ салбарт нэртэй төртэй ажиллаж байгаа эрдэмтдийн нэг бол доктор Д.Басандорж. ШУТИС-ийн профессор багш тэрбээр ус цэвэршүүлэх чиглэлээр сүүлийн үед олон талт ажлыг зохион байгуулж байна. Түүнтэй уулзаж ярилцлаа.*

**-Усны салбарт өнөөдөр тулгамдаж байгаа нэн чухал асуудал юу байна вэ?**

-Монгол Улсын Засгийн газраас боловсруулж УИХ баталсан “Ус” хөтөлбөр хэрэгжээд дуусч байна. Тэгэхлээр одоо нэн яаралтай усны бодлогын баримт бичигтэй болох хэрэгтэй байна. Цаашид ямар бодлого, чиглэлтэй явах юм бэ гэдгээ тогтож товлох ёстой юм.

**-Засаг төрөөс тодорхой үе шаттай бодлогууд боловсруулаад тэрийгээ хэрэгжүүлээд яваа гэж ойлгодог шүү дээ. Огт бодлогогүй яваад байсан юм байхгүй л болов уу?**

-Тийм ээ. Тэрийг үгүйсгэсэн юм биш л дээ. Усны тухай хууль, Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль, “Ус” үндэсний хөтөлбөр, Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөө гээд багагүй олон баримт бичгүүд байгаа ч эдгээрийн хэрэгжилт туйлын хангалтгүй байсаар хэрэгжих хугацаа нь дуусаж байна. Монголчуудад цогц бодлого үгүйлэгдээд байна, ус бол хөгжлийн суурь, нийгэм эдийн засгийн хөгжлийн үндэс гэсэн үзэл баримтлалаар хандахыг “цогц бодлого” гэж хэлээд байгаа юм.. Яг одоо Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Боловсролын салбарын нүхэн жорлонтой цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” ажлыг хэрэгжүүлэх техник технологи, үйл ажиллагааны талаарх уулзалт ярилцлага болж байна. Энэ ажилд гэхэд Монголын онцлогт тохирсон ямар техник, технологи байгаа юм гэдэг нь тодорхойгүй, эзэнгүй л байх жишээтэй. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын 819 ариун цэврийн байгууламжийн цэвэр, бохир усны асуудлыг цаг алдалгүй



шийдэхэд талуудын оролцоо чухал байна. Бохир усыг бүрэн цэвэрлэх Монгол технологи бэлэн байна, гэтэл бид гадны технологийг шүтэж, гадных бол “сайн” гэж үздэг хэвээр, өнөөдрийг хүртэл олон тэрбум төгрөг зарцуулсан ч бохир усаа стандартад нийцтэл цэвэрлэсэн бохир ус цэвэрлэх байгууламж туйлын цөөн байна. Энэ бүхэн нэгдмэл менежмент удирдлага, цогц уялдаа холбоотой бодлогогүйн илэрхийлэл юм.

**-Засгийн газар, бизнесийн байгууллагын үйл ажиллагаа хэрхэн яаж нэгдэж нийлэхээс тухайн ажлын хувь заяа бас ихээхэн хамаарч байна уу? Ер нь салангад олон нэгжүүдийг нэгтгэж базсан нэг том “дээвэр” байх ёстой гэж та үзээд байна аа даа?**

-Тийм ээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яам усныхаа нөөцийг хамгаалах тал дээр байдаг бол ХХААҮЯ бэлчээр усжуулалт, усалгаатай газар тариалан, Барилга хот байгуулалтын яам ус ашиглагч, хэрэглэгчийн талаас түлхүү хардаг, ханддаг байх жишээний. Усны асуудал салбар дамжин тарамдсан, нэгдсэн удирдлага зохицуулалтгүй явж ирсэн. Тийм болохоор салангад олон нэгжийг нэгтгээд Ерөнхий сайдын дэргэд нэг том байгууллага байхад болохгүй зүйлгүй. Нэгдсэн нэг зохион байгуулалт гэдэг манайд хамгийн чухал, усны засаглалыг бэхжүүлэх нь чухал байгаа юм.

**-Эрчимжсэн мал аж ахуй, усалтын систем бүхий газар тариалан хөгжих хандлага байна.**

***Ер нь уснаас хамааралгүй, уснаас ангид нэг ч салбар, нэгж, айл өрх, хувь хэн гэж байхгүй болохоор үнэхээр өргөн том талбарыг хамарч байна л даа?***

-Өдөр бүр бид устай харьцдаг, усгүйгээр амьдралыг төсөөлөх боломжгүй. Одоо усаа зөв удирдах нь хамгийн чухал. Эрх зүй, эдийн засгийн нэгдсэн зохицуулт хийх нь зөв. Усны нөөцөөс авахуулаад ашиглагч, бохирдуулагч гээд нэгдмэл системээр нь удирддаг бүтэц, тогтолцоо хэрэгтэй болжээ. Усны газар агентлаг саяхан бий боллоо. Энэ бас нэг том ололт. УИХ-д “Усны лоббий группууд”-ийг байгуулахыг зорьж байна. Ус, ундгүй бол бид мах идэхгүй, хүнсний ногоо байхгүй тиймээс эрчимжүүлсэн газар тариалан болон мал аж ахуй, фермерийн аж ахуй эрхлэхэд “ус” хамгийн чухал, түүний дотор “чанартай, хүрэлцээтэй ус” хангамжтай байж хүн амаа хүнсээр бүрэн хангаж, гадаадад экспортлох боломж бүрдэнэ.

***-Та ус цэвэршүүлдэг технологит ойр байдаг, ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг хүн. Энэ ажил манай улсад хэр ахиц дэвшилтэй явж байдаг юм бэ?***

-Тийм ээ, энэ бол их чухал асуудал шүү дээ. Ямарч бохирдолтой усыг “цэвэр ус” болгох технологийг бий болгож, инновацийг нэвтрүүлж, шинжлэх ухааны үндэслэлтэй, оюуны өмчөөр баталгаажсан шийдлүүдийг бий болгож байна. Ус бол стратегийн ач холбогдолтой хамгийн чухал баялаг, усны аюулгүй байдлыг хангасан Монгол улс байгаасай гэж би хүсдэг.

Монгол улсын иргэн бүхэн ундны цэвэр усаар хангагдах эрхтэй. Харамсалтай нь тэр эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй байна. Ундны ус бол онцгой анхаарах асуудал мөн. Монголын гурван хүн тутмын хоёр нь шүд нь хорхой идсэн шүд муутай байгаа нь устай бас холбоотой. Ходоод, элэг цэсний хорт хавдар ихтэй, цусны даралт өндөр байгаа нь ч устай холбоотой. Сүүлийн үед ус бохирдож, халдварт өвчлөл үүсэх эрсдэл бий болж байгаа “аюул” дуудаж байна. Миний хувьд 57 суманд ундны ус цэвэршүүлэх төхөөрөмж тавихад оролцож байсан, Монгол улсын нийт сумдын 70% нь ус хатуулаг ихтэй, эрдэс давс устай байдаг. Малчин хүн өөрөө усаа цэвэршүүлээд уучих боломжтой зөөврийн авсаархан технологи ч бий болсон байгаа. Бид мөн өнгөрсөн жил гурав дөрвөн газар ноос угаах үйлдвэрийн бохир усыг цэвэршүүлэх ажлыг хийлээ. Мөн аялал жуулчлалын баазууд, амралт сувилалын газрууд, сумын төвийн болон сургууль, цэцэрлэгүүдийн ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжуудыг барьж байгуулж “Монгол технологи” нэвтрүүлж хувь нэмрээ оруулж байна.

**-Тоног төхөөрөмжүүдээ гаднаас авч байна уу? Өөрсдөө хийж бүтээж байна уу?**

-Ер нь бол бид ОХУ, Хятад, Япон, Герман, Солонгос, АНУ гээд олон улс орны тоног төхөөрөмжийг тавьж туршсаар байгаад тэр дундаас “Монгол технологи”-оо гаргаад авсан. Энэ бол маш том олз, том боломж бололцоо, бидний хувьд технологийн “үүц” нөөц юм. Монголын бохир ус бол бас их өөр. Энгийг Япон, Америкийн ч тоног төхөөрөмж цэвэрлэж чадахгүй ээ. Өөх тос ихтэй, төрөл бүрийн угаач бодисоос хамаарч химийн бохирдол өндөртэй байдаг, манайхан ариутгал хийж байна гээд хлор их хэрэглэдэг нь бохир ус цэвэрлэдэг бичил биетнүүдийг үхэлд хүргэж, өмхий үнэр гаргах нөхцөл бүрдүүлдэг учраас Монголын бохир усыг цэвэрлэж чадах тийм технологийг бид туршилт судалгааны үр дүнд бий болгосон юм. “Буух эзэнтэй, буцах хаягтай” бол хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан, бас

бохирдолгүй эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд хэрэгтэй. Монголын цаг уур, орчин нөхцөлд тохирсон өөрсдийн гаргаж авсан юмаа хэрэглэж хэвшвэл экологийн хувьд, эдийн засгийн ч асар их үр ашигтай юм даа.

**-Бохир усыг цэвэр ус болгох тал дээр л ажиллаад байгаа хүн гэж таныг ойлгодог шүү дээ?**

-Өнөөдөр манай улс ахуйн хэрэглээндээ цэвэр усаа татаад бохироо бараг шууд хөрс, ус руу хаядаг тогтолцоотой байгаа. Энэ нь бид хэрэглэж буй усныхаа 60 хувийг жорлонгоороо дамжуулаад асгачихаж байна гэсэн үг. 200 литр ус хэрэглэж байна гэж бодоход 140 литрийг бид зөвхөн ахуйн болон бие засахдаа хэрэглээд жорлонгоороо дамжуулан урсгаж байна. Нэг татахдаа 9-13 литр ус урсгаж байна. Цэвэр усны нөөцөө хамгийн үр ашиггүй зарцуулж буйн нэг тод жишээ энэ юм. “Бохир ус”-гэдгийн “Бохир”-ыг авчихаар “Ус” л үлдэж байгаа биз дээ. Манайхан шиг уудаг цэвэр тунгалаг усаараа шалаа угаадаг, машинаа угаадаг, 00-ийн татуургаар асгаж байдаг үрэлгэн цамаан улс орон цөөхөн. Байгалийн цэвэр усыг хэн ч бүтээж чадахгүй. Тийм болохоор зүй зохистой, зөв хэрэглэхийг хэн хүнгүй л бодох хэрэгтэй. Усыг зөвхөн усны салбарынхан бус сургууль, цэцэрлэгээс авхуулаад хүн бүхэн ярьдаг хэлдэг, хичээдэг байх учиртай.

**-Саарал усаа ашиглана гэж чамгүй ярьж бичдэг. Энэ тал дээр ахиц, өөрчлөлт хэр гарч байгаа бол?**

- Энэ бол шийдэх боломжгүй, хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардаад байх ажил биш. “Саарал ус” гэдэг бол “хар ус” буюу жорлонгийн уснаас бусдыг хэлж байгаа ойлголт. Саарал усны системийг хөгжүүлэхэд усны үнэ цэнэ, үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Угаалтуур, шүршүүрийн усыг цэвэрлэж буцаан ариун цэвэр нойлын өрөөнд ашиглах замаар хэрэглээний усныхаа 60-70 хувийг дахин ашиглах бололцоотой. Саарал усны менежментийг нэвтрүүлэх хэрэгтэй. Стандарт бий болгох хууль эрх зүйн ажлыг эхлээд хийх хэрэгтэй байна.

Манай эрдэмтэн мэргэжилтнүүд 10 гаруй сургууль, цэцэрлэгийн зөөж аваачиж хаядаг бохир усыг тэнд нь цэвэршүүлээд ногоон байгууламжид нь ашигладаг ажлыг хэдийн хийгээд байна.

**-Сэтгэлгээ, хандлагаа өөрчлөх л их чухал юм байна даа**

-Ер нь бид ахуйн сэтгэлгээ, хандлагаа өөрчилж бохир усыг бохирдсон ус гэж бодоод урсгаж болохгүй, яг л шил лааз цуглуулдаг шиг бохир усыг түүхий эд гэж харах цаг болсон. Саарал ус ашиглахдаа энд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж байж асуудлыг шийднэ. Цэвэр усаар машинаа, шалаа угаадаг цамаан хэрэглээгээ хумих цаг болсон. Ус хэмнэж байгаа, бохир усыг цэвэрлэж эргүүлээд ашиглаж байгаа бол эдийн засгийн урамшуулал дэмжлэг үзүүлэх замаар эрх зүйн орчинг нэвтрүүлж, ядахдаа ус хэмнэдэг, ус цэвэрлэдэг технологи тоног төхөөрөмжийг гааль худалдаа, НӨАТ-өөс чөлөөлөх замаар цэвэр усныхаа нөөцийг хэмнэх хуулийг УИХ-ын гишүүд олонхоороо гараа өргөөд батлахад л болчихно. Мэдлэг, сэтгэл, ажил хэрэгч хариуцлагатай байдал үнэхээр ус агаар шиг дутагдаж байна даа.

**-Уг нь бол бид нандин сайхан уламжлалтай, газар дэлхий тэр тусмаа гол усандаа хамгийн нандин ханддаг уламжлалтай ард түмэн шүү дээ?**

-Үнэхээр Монголын ард түмэн ч тийм нандин өв уламжлалтай, төр засаг нь хатуу чанд хууль цаазтай байсан түүх бий. Харин энэ цагт Усны бодлогоо, усны соёлоо бид хаяж гээчихээд байна гэж хэлж болохоор байна. Эзэнт гүрний үед ус бохирдуулсан хүнийг цаазалдаг, бодоор торгодог байж. Ус бол амины үнэтэй гэдгийг тэгж ойлгуулж, ард түмэн нь ч бичигдээгүй олон хуулийг дагаж мөрддөг байсан. Одоо тэр уламжлалуудыг дахин сэргээж хатуу мөрддөг болох хэрэгтэй. Усны боловсролыг эхийн хэвлийгээс олгох хэрэгтэй, ерөнхий боловсролын сургуульд энэ талаар ямар ч хөтөлбөр хэрэгжихгүй байна. Усны үнэ цэнийг ойлгодог, усны талаар өндөр боловсролтой, шинэ үеийн Монголчууд бий болно гэж итгэж байна.

## ХӨВСГӨЛ НУУР-ЭГИЙН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА



### САВ ГАЗРЫН ЗАХИРГАА НЬ:

Сав газрын хэмжээнд усны нөөцийн хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий Төрийн захиргааны байгууллага юм.

### НУТАГ ДЭВСГЭР:

Хөвсгөл нуур-Эгийн голын сав газарт 2 аймгийн 11 сумын нутаг дэвсгэр багтаж байна. Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын нийт талбай нь 41679.92 км<sup>2</sup> байгаагаас Хөвсгөл аймгийн газар нутаг 33303.83 км<sup>2</sup> буюу 79.9 хувь, Булган аймгийн газар нутаг 8376.09 км<sup>2</sup> буюу 20.1 хувь тус тус эзэлж байна. Тус сав газар нь Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр, Ханх, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумын нутаг бүхлээрээ, Алаг-Эрдэнэ сумын 84 хувь, Түнэл сумын 76.6 хувь, Тариалан сумын 43.6 хувь, Ренчинлхүмбэ сумын 14.8 хувь Булган аймгийн Тэшиг сумын газар нутгийн 79.4 хувь, Хутаг-Өндөр сумын 38.7 хувь нь тус сав газарт хамрагдана.

Сав газрын нийт ус хурах талбай: 41,679.9км<sup>2</sup>, эгийн голын урт: 512 км. Хөвсгөл нуурын эзлэхүүн буюу усны нөөц 432 сая км<sup>3</sup>, гадаргын усны нийт нөөц 384.3-386.6 км<sup>3</sup> юм.

### САВ ГАЗРЫН АН АМЬТАН, УРГАМАЛ ЗҮЙ:

Уул нуруу, хөвч ой мод, гол мөрөн элбэгтэй учир ан амьтан, араатан, жигүүртэн, загас жараахай нутагшин байрших, үржин төлжих таатай орчинтой. Цаа буга, аргаль угалз, янгир, халиу, буга, суусар, баавгай, буга, хүдэр, гахай, буга, бор гөрөөс, тарвага, үнэг, хярс зэрэг амьтадтай. Сав газарт 20 зүйлийн загас, 4 зүйлийн хоёр нутагтан, 4 зүйлийн хэвлээр явагч 66 зүйлийн хөхтөн, 244 зүйлийн шувуу байдаг.

Ургамал зүйн хувьд 2100 гаруй зүйлийн гуурст ургамал байгаагийн 100 гаруй нь эмийн, 500 гаруй нь тэжээлийн 10 гаруй нь хүнсний, 4 нь техникийн, 300

гаруй нь зүйлийн гоёл чимэглэлийн ургамал байдаг ба 243 зүйлийн хөвд 600-гаад зүйлийн хаг, 739 зүйлийн замаг, 389 зүйлийн мөөг ургадаг бол нэн ховор ургамал 34 зүйл, монголын улаан номонд орсон 36 зүйл цэцэгт ургамал байдаг.

### САВ ГАЗРЫН ОНЦЛОГ ХӨВСГӨЛ НУУР

Монгол орны хойд хэсэгт байрлах цэнгэг уст нуур нь “Хорьдол Сарьдаг”, “Уран дөш” зэрэг өндөр нуруудаар хүрээлэгдэн далайн түвшинээс дээш 1650 м өндөрт оршино.

Хөвсгөл нуур эзлэхүүнээрээ манай улсын хамгийн том нуур бөгөөд улсын хэмжээнд хамгийн гүн нуур юм. Цэнгэг усны нөөцөөрөө

Монгол улсад нэгдүгээрт орох бөгөөд монгол орны цэнгэг усны нөөцийн 70 хувь, дэлхийн нийт цэнгэг усны нөөцийн 0,4 хувийг эзэлнэ.

- Усны дундаж эзлэхүүн 383 км<sup>3</sup>
- Хамгийн гүн нь 239 м
- Дундаж гүн нь 138 м болно.
- Нуурын урт нь 136 км
- Өргөн 36.5 км
- Усан мандлын талбай 2760 км<sup>2</sup>
- Нуурын ус хурах талбай 4925 км<sup>2</sup>

### ЭГИЙН ГОЛ:

Хойд мөсөн далайн ай савд багтах бөгөөд Хөвсгөл нуураас эх аван ой хөвч дундуур урсан Үүр голтой нийлж улмаар Сэлэнгэ мөрөнд цутгана. Эгийн гол бол 7 дугаар эрэмбийн гол бөгөөд Үүр, Уйлгана гэсэн манай орны томоохон голууд цутгана.

Хөвсгөл нуураас эх авсан цэгээс Сэлэнгэ мөрөнд цутгах хүртэл 512 км урсана.

Эгийн гол ой хөвч бүхий бэсрэг уулс дундуур урсдаг ба түүний өргөн Үүр голын бэлчир хүртэл 20-70 м, түүнээс доош 50-150 м хүрнэ.

### 2021 ОНД ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙГАА ОНЦЛОГ АЖЛУУД:

- Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаанд хамтран оролцох, нуурт унасан автомашиныг татаж гаргах
- Эгийн голын дагуу хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах
- Хөвсгөл аймгийн татварын хэлтэстэй хамтран усан замын тээврийн үйлчилгээ эрхэлдэг иргэн, ААН-ийн төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ, орлогыг тогтоох зорилгоор үйл ажиллагаанд ажлын зураг авалт хийж, жишиг үнийн дүнг аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулах ажлыг төлөвлөөд байна.

## МОНИТОРИНГИЙН СҮЛЖЭЭНИЙ ХЯНАЛТ-УДИРДЛАГЫН ПОРТАЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



“Монгол орны газрын доорх усны мониторингийн сүлжээний хяналт-удирдлагын портал хөгжүүлэлт” төслийн үр дүнг албан ёсоор хүлээлгэн өглөө.

Монгол улсын усны менежментэд газрын доорх усны мониторингийн Хяналт-Удирдлагын Порталыг хөгжүүлж, газрын доорх усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын хэтийн төлөвийг тооцох загварчлалыг Хиймэл оюун ухааны дэд салбар болох Машин сургалтын (Machine Learning) арга хэрэгсэлийг ашиглан боловсруулах ажлыг Дэлхийн банкны дэргэдэх 2030 УНБ-ийн Монголын болон Энэтхэгийн баг, БОАЖЯ, Засгийн газрын

хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын, БНЭУ-ын мэдээлэл технологийн “Блобсити” компани, Монгол улсын мэдээллийн технологийн “КПМ” компанитай хамтран 2018-2020 оны хооронд хийж гүйцэтгэсэн.

Төслийн хүрээнд хөгжүүлсэн Улсын усны хяналт шинжилгээний groundwater.mn нэгдсэн порталыг хүлээлгэн үйл явдлыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр УСНЫ ГАЗРЫН “ХАТАН ТУУЛ” танхимд 10:00-12:00 цагийн хооронд зохион байгуулав. Энэхүү үйл явдалд Усны Газрын дарга Ш.Мягмар, БОАЖЯ-ны Усны бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мөнхбат, 2030 УНБ-ийн Монгол дахь суурин зохицуулагч доктор Д.Доржсүрэн, Мэдээллийн технологийн “КПМ” компанийн захирал Ш.Эрдэнэбаатар нарын хүмүүс оролцлоо.

Монгол орны хэмжээгээр өнөөгийн байдлаар хүн амын нягтшил, нийгэм-эдийн засгийн хөгжил, газрын доорх ус ашиглалтын байдлаас хамааран Groundwater.mn Мониторингийн нэгдсэн сүлжээнд нийт 280 хяналтын цооног бүртгэлтэй ажиллаж байна.



«Усны ажил бүтвэл улсын ажил бүтнэ» гэж бид ярьж хэлэлцдэг билээ. Усны төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж буй манай салбарын ажилтанууд төр засгийн өндөр шагнал, алдар цол хүртсээр байна. Дэлхийн усны өдрийн өмнөхөн Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны дарга Ю.Сувдчимэг Төрийн дээд "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн"-ийн одонгоор шагнагдлаа. Ю.Сувдчимэгт Усны газрын хамт олноос баяр хүргэж байна.

### САВ ГАЗРУУДААР СОНИН ЮУТАЙ БАЙНА ВЭ?

- Увс нуур-Тэс голын сав газрын захиргаанаанаас энэ жил “Тэсийн голын монголчууд” сэдэвт фестивал зохион байгуулна. Мөн булаг, ус гол, нуур цөөрөм, рашааны тухай домог түүх цуглуулах уралдаан зарлаж товхимол болгож хэвлүүлнэ.
- Онги Таац голын сав газрын захиргаанаас Арвайхээр сумын ундны усны нөөцийг тогтоох хайгуул судалгааны ажлыг эхлүүлэх, Дэлгэрэх гол төслийн Арвайхээр сумын ТИС-ийн гүүрнээс Нисэхийн гүүр хүртэлх 680м газарт голын голдиролыг шулуутгах, орчны тохижилтыг хийх ажлыг үргэлжлүүлж, Орхон Онги төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, судалгаа шинжилгээний ажилд хамтран ажиллаж байна.
- “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Ус үндэсний хөтөлбөр, Улсын УННМТ зэрэг бодлогын баримт бичгүүдэд Монгол орны хэмжээнд гол мөрний урсац бүрэлдэх эхийн 70-80 хувийг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд нэгтгэхээр төлөвлөсөн байдаг. Тус зорилтын хүрээнд Туул голын сав газрын захиргаа нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.12 дэх хэсэгт заасан эрх үүргийн дагуу Туул голын баруун урд хэсгээс цутгадаг томоохон цутгал болох Хар бухын гол (Тарнайн гол)-ын урсац бүрэлдэх эх буюу Дулаан хаан, Сантын нуруу орчмыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөн ажиллаж байна.
- Недарландын Вант улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжаар 2008-2012 онд хэрэгжүүлсэн “Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Туул голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулж 2013-2021 онд хэрэгжүүлж дууссан. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 онд багтаж Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулахаар ажиллаж байна.
- Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа Дорноговь аймгийн газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, мөн тус аймагт гадаргын усны тоо бүртгэлийг явуулж усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн зураглалын ажил хийнэ.
- Хэрлэн голын сав газрын захиргаа нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Мөнххаан сумдад 64344 га талбай бүхий усны сан бүхий газрын хамгаалалтын бүс гатаж, ИТХ-ын тогтоолын төслийн хавсралтыг боловсруулж аймгийн БОАЖГ газарт хүлээлгэн өглөө. Онцгой хамгаалалтын бүс 44990 га, энгийн хамгаалалтын бүс 19354 га байна. Энэ онд хамгаалалтын бүсийг аймгийн ИТХ-аар батлуулах гэж байна.

## “ХУУРАЙ ҮЕР” ЮУГ САНУУЛАН ХЭЛЭВ?



Монголын байгалийн уран бүтээлчдийн холбооны төлөөлөл.

Дэлхийн усны өдөрт зориулан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”, “Монголын байгалийн уран бүтээлчдийн холбоо”, Соёлын яам хамтран “Хуурай үер” үзэсгэлэнг дэлгэн толилууллаа. Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд 3 дугаар сарын 15-нд нээлтээ хийсэн энэ үзэсгэлэнд уран зураг, видео арт, өрөг урлаг, фото арт, үйлдлийн урлаг гэсэн дүрслэх урлагийн таван төрлөөр хийгдсэн 20 гаруй бүтээлийг тавьжээ.



«Нийгэмшил» М.Мөнх-Эрдэнэ

Байгаль орчин, тэр тусмаа усны асуудал уран бүтээлчдийн сэтгэл зүрхэнд ямар сэрэл мэдрэмж, эмзэглэл, эгшиг аялгуу болж бууж байгааг тэд дүрслэх урлагийн хэлээр гарган хэлэхдээ “Хуурай үер” хэмээн “хашгирлаа”. Энэ тухай тус үзэсгэлэнг зохион байгуулсан зураач Н.Амарсайхан: “Агаарын бохирдол, дэлхийн дулаарал, цөлжилт болон усны хомсдол зэрэг аюулын харанга дэлдсэн аймшигт асуудлуудад дэлхий нийтээрээ анхаарал хандуулж, сэтгэл түгшин тэмцэх болсон билээ. Энэхүү тэмцэлд нэгдэж, “Цөлжилт” гэдэг аюулын харангыг урлагийн хэлээр олон нийтэд хүргэж сонсохын тулд манай холбооны уран бүтээлчид, “Цөлжилт урлагт” 2011 оны 6-р сард, “Элсэн Цунами” 2012 оны 6-р сард

төслийн үзэсгэлэнгүүдийг зохион байгуулж Дэлхийн цөлжилтийн өдөрт зориулан нээж, нийтийн хүртээл болгосон нь амжилттай болсон юм. Мөн Дэлхийн усны өдөрт зориулж 2012 оны 3 сарын 22-нд Төрийн ордонд “Ус Эрдэнэ”, “Усгүй Урсгал” “төслийн үзэсгэлэнгүүдийг тус тус зохион байгуулсан билээ.

Манай холбоо нь 2019 онд “Хөх Тоонот” нэртэй Унгар, Монголын 20 гаруй уран бүтээлчдийн хамтарсан солилцоо хөтөлбөрийг Монголд болон Румын улсын Трансильвания хотод нийт нэг сар гаруй хугацаанд амжилттай зохион байгуулаад байна.



«Нэг бүхэл» Р.Чинзориг

Өнгөрсөн жил бид “Global Nomadic Art Project-2020 Mongolia” / GNAP/ төслийг Монголын тал нутагт “Чимээгүй Цуурай” нэртэйгээр зохион байгуулах байсан хэдий ч цар тахлын улмаас хойшлогдсон. Гэсэн хэдий ч энэхүү арга хэмжээгээ бид онлайн олон улсын үзэсгэлэн болгон зохион байгуулж 9 орны 20 уран бүтээлчдийг оролцуулан байгалийн урлагийг орчин үеийн дүрслэх урлагийн төрлүүдээр олон нийтийн сүлжээгээр дэлхий дахинд үзүүллээ.



«Зүүдний зэрэглээ» Г.Энхжаргал



«Үг» Ц.Түвшинжаргал, С.Батсайхан

Бид 2021 онд 9-р сард GNAP-2021 Mongolia төслийг, 7-р сард олон улсын резиденс хөтөлбөрийг монголд хийхээр төлөвлөөд байгаа” гэлээ.



«Аниргүй эзэн» Р.Чинзориг

“Хуурай үер” үзэсгэлэнд Л.Энхбат, Н.Амарсайхан, Р.Лувсандорж, М.Мөнх-Эрдэнэ, Г.Энхжаргал, Ц.Түвшинжаргал, С.Батсайхан, Т.Энхболд нарын есөн зураач уран бүтээлээ толилууллаа. Нээлтийн үеэр Т.Энхболд “Тэнцвэр үгүй тэнцвэр”, Г.Энхжаргал “Зүүдний зэрэглээ” нэртэй үйлдлийн урлагийн бүтээлээ үзүүлсэн нь нэн сонирхолтой байлаа.



«Усны нүүдэл» Н.Амарсайхан